

ГАРЧИГ

- 1–3 Бодлогын нийтлэл
- 4–7 Зохицуулалтын мэдээ
- 8–9 Ярилцлага
- 10–11 Тогтвортой санхүүжилт
- 12–13 Компанийн засаглал, комплайнс
- 14–15 Финтек ба регтек
- 16–23 Судлаачийн индэр
- 24–25 Гэнэтийн ослын, эмчилгээний даатгал гэж вү вэ?
- 26–27 Олон улсын зах зээлийн мэдээ
- 28 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

REIT БУЮУ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭЛ /САН/-Г МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

REIT/Real estate investment trust/ нь үл хөдлөх хөрөнгө худалдан авч, түүнээс ногдол ашиг хэлбэрээр орлого олж өгөөж хүртдэг санхүүгийн хэрэгсэл юм. Олон улсад хөрөнгө оруулагчдын сонирхол уламжлалт бус хөрөнгө оруулалтын чиглэлд өсөн нэмэгдэж буй энэ үед REIT нь өндөр өгөөж хүртэх боломжийг санал болгодог. Мөн бусад хөрөнгөөс харьцангуй бага хамааралтай байдаг нь хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэхэд тохиромжтой бөгөөд энэ нь нийт багцын эрсдэлийг бууруулж, өгөөжийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Түүнчлэн REIT нь татвар ногдуулах орлогынхоо дийлэнх хувийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашгаар хуваарилах үүрэгтэй байдаг нь тогтмол орлого хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээр татдаг байна.

REIT-ууд нь олон төрөл, хэлбэртэй байдаг бөгөөд дийлэнх тохиолдолд хамтын хөрөнгө оруулалтын сантай адил хувьцаа буюу нэгж эрх гаргаж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийн эх үүсвэр татдаг бөгөөд хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэн олон нийтийн дунд нээлттэй арилжаалагддаг.

REIT-ыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх нь хөрөнгө оруулагчдын хувьд хөрөнгө оруулалтын боломжуудыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах, энэ нь цаашлаад үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, менежментийн салбарт ажлын байр бий болгохын зэрэгцээ эдийн засгийн өсөлтийг дэмжих давуу талтай.



Эх сурвалж: Allen & Gledhill LLP

Дээрх бүтцээс харвал REIT-ын нэгж эрхийг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгодог. REIT-ын менежментийг ихэвчлэн үл хөдлөх хөрөнгөөр мэргэшсэн хөрөнгийн удирдлагын компани /asset management/-иуд хийдэг. Үүний зэрэгцээ REIT-ууд нь үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг хадгалахын тулд урт хугацааны засвар үйлчилгээ, засварын төлөвлөгөөг боловсруулж, төлөвлөсөн хуваарийн дагуу хэрэгжүүлдэг. Ихэнх REIT-ууд жилийн менежерийн хураамж, үл хөдлөх хөрөнгийн менежерийн хураамж, итгэмжлэгдсэн өмчлөгчийн хураамж болон бусад зардлыг орлогоос суутгаж тооцсоны үндсэн дээр нэгж эрх эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилж тооцдог байна.

Үргэлжлэлийг 2-р нүүрт



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

*БОНЗ (Байгаль орчин, нийгэм, засаглал)

/ESG (Environmental, Social, and Governance)/

Компанийн үйл ажиллагааг үнэлэхэд ашигладаг шалгуур буюу хөрөнгө оруулалт хийхдээ байгаль орчны, нийгмийн болон засаглалын асуудлыг нэн тэргүүнд тавих тухай зарчим. БОНЗ нь 2023 он гэхэд НҮБ-ын нийгмийн хариуцлагын санаачилгын 30 их наяд гаруй ам.долларын менежментийн хөрөнгийг төлөөлдөг хөдөлгөөн болон өргөжсөн.



ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР ТОЛЬ

Нэмж, сайжруулсан хоёр дахь хэвлэл

Байгууллагын тогтвортой байдлын стратеги

/Corporate Sustainability Strategy/

Эдийн засаг, байгаль орчин, нийгмийн хөгжлийн үр дүнд оролцогч талуудад үнэ цэн бий болгох, бизнесийн боломжийг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн урт хугацааны бизнесийн үйл ажиллагаа. Үүний үрээр компаниуд өөрсдийн нэр хүнд, брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжтой.

Эх сурвалж: Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

REIT БУЮУ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭЛ /САН/-Г МОНГОЛ УЛСАД НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Эхлэл нь 1-р нүүрт

REIT-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД:

REIT-ын менежер

REIT-ын хөрөнгийг менежер удирддаг. REIT-ын тодорхойлсон хөрөнгө оруулалтын стратегийн дагуу менежер нь REIT-ын стратегийн чиглэлийг тодорхойлох, суурь хөрөнгийг худалдан авахтай холбоотой эрх үүргийг хэрэгжүүлдэг.

Үл хөдлөх хөрөнгийн менежер

Үл хөдлөх хөрөнгийн менежерийг ихэвчлэн REIT-ын менежер томилдог бөгөөд REIT-ийн суурь үл хөдлөх хөрөнгийг удирддаг. Үл хөдлөх хөрөнгийн менежер нь түрээсийн орлогыг нэмэгдүүлэх, үл хөдлөх хөрөнгийг түрээслэхэд хяналт тавих, маркетингийн арга хэмжээ эсвэл сурталчилгааны хөтөлбөр зохион байгуулах, үл хөдлөх хөрөнгийн засвар үйлчилгээтэй холбоотой эрх үүргийг хэрэгжүүлдэг.

Trustee буюу итгэмжлэгдсэн өмчлөгч

Итгэмжлэгдсэн өмчлөгч нь REIT-ын нэрийн өмнөөс хөрөнгө эзэмших үүрэгтэй бөгөөд нэгж эрх эзэмшигчдийн ашиг сонирхлыг төлөөлдөг. Итгэмжлэгдсэн өмчлөгчийн үүргийг REIT-ын итгэмжлэлийн гэрээнд тусгасан байдаг бөгөөд эдгээрт ихэвчлэн холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх, үл хөдлөх хөрөнгийн хадгалалт, нэгж эрх эзэмшигчийн тодорхой эрхийг хамгаалах зэрэг зүйлс орсон байдаг.

Улс орнуудын REIT-д тавигддаг нийтлэг шаардлага

- ◆ REIT-ийн татварын орлогын хамгийн багадаа 90 хувийг ногдол ашигт төлдөг байх (жишээлбэл ОХУ);
- ◆ Татварын жилийн сүүлийн хагасын туршид өөрийн хувьцааны 50 хувиас ихгүй хэмжээний хувьцааг 5 эсвэл илүү цөөхөн хувь хүмүүсийн хяналтад байлгах (жишээлбэл АНУ, ОХУ);
- ◆ REIT-ийн хөрөнгийн 75 хувиас доошгүй хувь нь үл хөдлөх хөрөнгө байх ёстой бөгөөд нийт орлогын 75 хувиас доошгүй хувь нь түрээс, ипотекийн хүү эсвэл үл хөдлөх хөрөнгийг борлуулсны орлогоос бүрдэх (жишээлбэл АНУ, Их Британи, Хонконг, Тайвань);
- ◆ REIT-ийн нийт орлогын хамгийн багадаа 95 хувь нь санхүүгийн хөрөнгө оруулалтаас бүрдсэн байх ёстой. Үүнд, түрээс, ногдол ашиг, хүү болон капиталын орлого хамаарна (жишээлбэл АНУ);
- ◆ Хамгийн багадаа 100 нэгж эрх эзэмшигчтэй байх (жишээлбэл АНУ, ОХУ).

REIT-ийг Монгол Улсад нэвтрүүлэх

Олон улсын туршлагаас харахад зарим улс орнууд тусдаа REIT-тэй холбоотой хуультай байдаг хэдий ч ихэнх тохиолдолд холбогдох үнэт цаас болон хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомжийн хүрээнд REIT-ууд үйл ажиллагаагаа явуулдаг байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хууль санаачлах эрх бүхий субъект биш ч “Монгол Улсын Засгийн Газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Үл хөдлөх хөрөнгийн салбарын хамтын хөрөнгө оруулалтын санг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх тухай тодорхой зорилт туссан бөгөөд үүнтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс REIT-ын үйл ажиллагааны талаарх зохицуулалтын орчны талаар холбогдох судалгааг хийж, хууль зүйн үндэслэл, шаардлага болон хуулийн төслийг боловсруулахаар ажиллаж байна.

REIT-ыг Монгол Улсад үр дүнтэй нэвтрүүлэхийн тулд REIT-ын тухай бие даасан хуулийн төсөлд REIT-ын төрөл, хэлбэр, удирдлага, үйл ажиллагаа, REIT-ыг үүсгэн байгуулахтай холбоотой зохицуулалтыг тусгах шаардлагатай бөгөөд дараах гол асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай:

- ◆ **Татварын зохицуулалт:** Олон улсын туршлагаас харахад REIT-ууд татварын тодорхой хөнгөлөлт эдлэх замаар хөрөнгө оруулалтыг дэмждэг. Жишээлбэл, АНУ, Их Британи зэрэг орнуудад татвар ногдох орлогын тодорхой хувийг (ихэвчлэн 90 хувиас дээш) хувьцаа эзэмшигчдэд хуваарилах шаардлага тавьдаг бөгөөд ингэснээр аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгддөг.
- ◆ **Өрийн хэмжээнд хязгаарлалт тогтоох:** Зарим улс оронд REIT-ын зээлийн хэмжээнд хязгаарлалт тогтоосон байдаг. Жишээлбэл, Их Британи REIT-ийн зээл, хөрөнгийн харьцааг 35 хувиас хэтрэхгүй байхыг шаарддаг. Иймээс санхүүгийн эрсдэлээс сэргийлэхийн тулд REIT-ын зээл, хөрөнгийн түвшнийг зохицуулах шаардлагатай.
- ◆ **Хөрөнгө оруулагчдын хамгаалалт, ил тод байдал:** Хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахын тулд REIT-уудын үйл ажиллагаанд ил тод, хатуу тайлагналын шаардлагыг тавих хэрэгтэй. Япон, Сингапур зэрэг орнууд тайлагнал, компанийн засаглалын стандартаар хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалдаг.
- ◆ **Хөрөнгө оруулалтын хязгаарлалт ба өмчлөл:** Зарим улс оронд нэг этгээд REIT-ын тодорхой хувиас илүү

хувьцаа эзэмшиж болохгүй хязгаарлалт тавьдаг. Жишээлбэл, АНУ-д зах зээлийн төвлөрлөөс сэргийлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор REIT-ын хувьцааны 50 хувиас илүүгүйг тав буюу түүнээс цөөн хувь хүн эзэмшихийг хориглодог. Иймээс REIT-ын өмчлөл болон хөрөнгө оруулалтын хязгаарлалтыг тогтоох шаардлагатай.

- ◆ **Барилгын компаниудын тусгай зөвшөөрөл ба чанарын хяналт:** Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд барилгын чанар, аюулгүй байдал чухал үүрэгтэй. Иймээс REIT-ын хөрөнгө оруулалтын хүрээнд дуусаагүй болон дууссан барилгад хөрөнгө оруулах нөхцөл, шаардлагыг тодорхой болгох шаардлагатай.

REIT-ыг хөрөнгийн зах зээлд нэвтрүүлснээр хувь хүн, жижиг дунд бизнесүүд үл хөдлөх хөрөнгөд шууд бус хөрөнгө оруулалт хийх боломжийг олгож, хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээл болон үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн талаарх мэдлэг, боловсрол сайжрах, хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх, үнэт цаасанд хөрөнгө оруулсан эрсдэлээ бууруулах улмаар хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар сайжирч, зах зээл илүү өргөжих давуу талтай юм. Нөгөө талаараа Монгол Улсад сүүлийн жилүүдэд үл хөдлөх хөрөнгийн салбар асар хурдацтай өсөж байна. Үүнийгээ дагаад уг төслүүдэд эх үүсвэрээ бий болгох хөрөнгө оруулалтын шинэлэг боломжууд дутагдаж байна. REIT нь үл хөдлөх хөрөнгийн салбарын томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх оновчтой арга хэрэгсэл бөгөөд барилгын төслүүдийн хэрэгжилт түргэсэх нь эдийн засгийн идэвхжилтийг нэмэгдүүлж, ажлын байр олноор бий болгож, эдийн засгийн эргэлтийг хурдасгах давуу талтай юм.

Манай улсын ДНБ-ий дунджаар 8 гаруй хувийг барилга болон үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбар бүрдүүлж байна. Уул уурхайн орлогоос хамааралтай эдийн засгийн бүтэцтэй Монгол Улсад REIT-ыг нэвтрүүлснээр үл хөдлөх хөрөнгийн салбарыг эдийн засгийн дараагийн өсөлтийн хөдөлгөгч хүч болгон хувиргаж, зээлийн хүүг бууруулах, эдийн засгийн мөчлөгийг түргэсгэх, хөрөнгө оруулалтын хүртээмжийг нэмэгдүүлэх олон талт үр дүнд хүрэх боломжтой. Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос REIT-ыг хөгжүүлэх чиглэлд бодлогын дэмжлэг үзүүлж, тогтвортой хөрөнгө оруулалтын шинэ орчныг бий болгохоор ажиллаж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ



БИЗНЕС ЭРХЛЭГЧ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг. Энэ хүрээнд зохицуулалтын байгууллагуудтай хамтран бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд "Хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжууд" сургалтыг зохион байгууллаа.



Сургалтаар "Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, бодлого зохицуулалт", "Хөрөнгийн бирж дээр санхүүжилт татах боломжууд", "Биржийн бус зах зээл дээр санхүүжилт татах арга аргачлал", "Тогтвортой санхүүгийн суурь ойлголт, чиг хандлага" гэсэн сэдвийн хүрээнд мэдээлэл өгч мэдлэг олгосон. Мөн тогтвортой санхүүжилт, ногоон бизнес эрхлэхийн давуу тал, боломжуудын талаар танилцуулав. Санхүүгийн зохицуулах хорооны "Санхүүгийн

хүртээмж" танхимд болсон сургалтад нийт 25 бизнес эрхлэгч хамрагдлаа.

ЭНЭ ОНЫ АНХНЫ БОНДЫН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЖ ЦАН ЦОХИЛОО

"Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй бондын анхдагч зах зээлийн арилжааны цан цохих арга хэмжээ боллоо. Арга хэмжээнд Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн бизнес, хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ, "Өлзий энд КО капитал ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр, "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК-ийн ТУЗ-ийн дарга А.Алтансүх, гүйцэтгэх захирал Ц.Бат-Эрдэнэ болон холбогдох бусад хүмүүс оролцлоо.



Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал нээж хэлсэн үгэндээ "Хөрөнгийн зах зээлийн 2025 оны анхны бүтээгдэхүүн гарч байна. Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ нэр төрлийг нэмэгдүүлэх хүрээнд цогц арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлснээр сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл идэвхжиж, зах зээлийн үнэлгээ 13.02 их наяд төгрөгт, арилжааны дүн 1.58 их наяд төгрөгт хүрээд байна. Мөн ДНБ-д эзлэх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 18.5 хувьд хүрч өссөн амжилтыг үзүүлээд байна. Энэ нь нэг талаар УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний үр дүн, нөгөө талаас дэд бүтцийн байгууллагууд, хөрөнгө оруулагчдын идэвх оролцоо буюу төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үр өгөөж юм. Мөн өнгөрсөн оны хөрөнгийн зах зээлийн онцлох үйл явдлын нэг нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан явдал. Ингэснээр санхүүгийн зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж, дотоодын компаниуд бонд гаргах ажиллагаа хялбар, шуурхай болохын зэрэгцээ зохицуулагч болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн уялдаа холбоо сайжирч олон улсын жишигт

нийцэх, үнэт цаасны арилжаа, клиринг, төлбөр тооцоо, төвлөрсөн болон тухайлсан бүртгэлтэй холбоотой зохицуулалт боловсронгуй болох зэрэг өгөөж арвин өөрчлөлт бий болсон. Тухайлбал, шинэ бүтээгдэхүүн буюу хадгаламжийн сертификат, хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа, үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх эрх зүйн орчин бүрдэж холбогдох журмуудыг бид боловсруулаад, батлахад бэлэн болоод байна. Ингэснээр гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүжилт татах боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх хүрээнд зохицуулалтын орчин боловсронгуй болно” гэдгийг онцолсон юм.

ЖОЛООЧ, ДААТГУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал даатгуулж, даатгуулагч зам тээврийн осол гаргасан тохиолдолд бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой харилцааг зохицуулдаг бөгөөд даатгалын нөхөн төлбөр олгоход цагдаагийн тодорхойлолт шаардлагатай эсэх талаарх дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 3.6–д “Зам тээврийн ослын үед хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, осолд холбогдсон жолооч нарын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгөд хохирол учраагүй, ослоос үүдсэн эд хөрөнгийн хохирлыг жолооч нар өөр хоорондоо буюу даатгалын байгууллагатай харилцан маргаангүй шийдвэрлэхээр тохиролцсон бол энэ дүрмийн 3.5–ын “г”–д заасан үүргээс чөлөөлөгдөж болно.” гэж заасан байдаг. Үүний дагуу, зам тээврийн осолд холбогдсон жолооч нар нь ослын талаар аливаа маргаангүй, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, даатгагчийн заавар зөвлөмжийн дагуу холбогдогч талууд тохиолдлыг баримтжуулж, талууд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд даатгагч нь даатгуулагчид тээврийн цагдаа дуудах шаардлага тавихгүй байх, мөн цагдаагийн тодорхойлолт заавал шаардахгүйгээр даатгалын нөхөн төлбөрийг олгоно. Харин зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан, жолооч архи, мансууруулах бодис хэрэглэсэн, талууд даатгалын тохиолдолд гэм буруутай эсэх талаар маргаантай нөхцөлд тээврийн цагдаагийн албанд дуудлага өгөх нөхцөл бүрдэх юм. Энэхүү зохицуулалт болон жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, гомдол байвал даатгуулагч та, Санхүүгийн зохицуулах хорооны 51–261275 тоот утсанд хандах боломжтой.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Т.ЖАМБААЖАМЦ ҮҮРЭГТ АЖЛАА ХҮЛЭЭЖ АВЛАА



Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 01 дүгээр сарын 16–ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Т.Жамбаажамцыг томиллоо. Үүнтэй холбогдуулж УИХ–ын тогтоолыг танилцуулж тамга гардуулах арга хэмжээ болж УИХ–ын ЭЗБХ–ны дарга Р.Сэддорж, УИХ–ын гишүүн Н.Батсүмбэрэл, УИХ–ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, УИХ–ын Тамгын газрын дэд дарга Ү.Амарбат болон Санхүүгийн зохицуулах хорооны газар, хэлтсийн дарга нар оролцлоо.

УИХ–ын ЭЗБХ–ны дарга Р.Сэддорж энэ үеэр “Юуны өмнө санхүүгийн салбарыг бүхэлд нь зохицуулдаг энэ том байгууллагыг хариуцлагатай удирдаж, салбарын өсөлтийг үзүүлж чадсан Д.Баярсайхан даргадаа цаашдын ажил, амьдралд нь өндөр амжилт хүсье. Мөн УИХ–ын нэгдсэн хуралдаанаар олонхийн саналаар дэмжиж баталсан Т.Жамбаажамц даргадаа УИХ–аас гаргасан зорилтууд, бодлогын ажлууд болон УИХ–аас өгсөн захиас даалгаврыг баг, хамт олонтойгоо амжилттай хэрэгжүүлж ажиллах их амжилтыг хүсье” гэсэн юм.

Ингээд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамцад Санхүүгийн зохицуулах хорооны дарга асан Д.Баярсайхан тамгыг гардуулсан бөгөөд тэрбээр энэ үеэр “Өнгөрсөн таван жилийн хугацаанд ДНБ–д эзлэх Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбарын нийт хөрөнгийн хэмжээ 3.5 дахин өсөж, 19.6 их наяд төгрөгт хүрсэн бол зөвхөн хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 4.0 дахин нэмэгдэж, 12.1 их наяд төгрөгт хүрээд байна. Банкны салбарын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлснээр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 5.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн гээд ололт, амжилт арвин байлаа. Зохицуулалтын салбаруудын эрх зүйн шинэчлэл, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, тогтвортой, ногоон санхүүжилт, санхүүгийн технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх ажлууд ч ид хэрэгжиж байгаа бөгөөд энэ бүх

ажлыг хамтдаа бүтээлцсэн Санхүүгийн зохицуулах хорооны нийт хамт олондоо талархлаа илэрхийлэхийн сацуу Т.Жамбаажамц даргадаа ажлын амжилт хүсье” гэв.

Харин Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц энэ үеэр “Санхүүгийн салбарын тогтвортой байдал, ирээдүйн өсөлт, хөгжлийн тулгуур болсон реформ, шинэчлэлийг хэрэгжүүлэх ажлыг цаашид үргэлжлүүлж, итгэл, хариуцлагыг дааж ажиллана. Мөн УИХ–ын дарга, гишүүдээс өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх, салбарын өсөлтөө ахиулахын төлөө шинээр томилогдсон гишүүд болон нийт баг, хамт олонтойгоо хамтдаа хичээж ажиллана” гэдгийг онцолсон юм.

УИХ–ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж түүний дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хорооны орон тооны бус гишүүнээр Б.Саруул, Ш.Хандсүрэн нарыг, Хяналтын зөвлөлийн даргаар М.Буяндэлгэр, гишүүнээр О.Оч, Б.Энхбаяр, Ч.Сайнбилэг, С.Халиунаа нарыг тус тус томилсон УИХ–ын тогтоолыг танилцуулсан юм.

СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ №5 ХЭВЛЭГДЭН ГАРЛАА



Санхүүгийн зохицуулах хорооноос жил бүр эрхлэн гаргадаг “Судалгааны товхимол”–ын шинэ дугаар уншигч танд хүрч байна. Олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын

хүрээнд аливаа шийдвэрийг гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэж урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог. Санхүүгийн зохицуулах хороо үүний адил олон улсын шилдэг туршлага, стандартыг хяналт, зохицуулалтдаа нэвтрүүлэх, судалгаа шинжилгээний үндсэн дээр шийдвэр гаргах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, системийн эрсдэлийг урьдчилан тооцсон урт хугацааны хөгжлийн стратеги бий болгоход анхаарч ажилладаг бөгөөд энэ хүрээнд хийсэн судалгааны ажлуудаа цувралаар хүргэсээр тав дахь жилээ золгож байна.

Энэхүү товхимолд мөнгөний зах зээл ба зохицуулалтын орчин, уур амьсгалын бондын стандарт, шаардлага, Монгол Улсад гадаад брокер орж ирэх, зайнаас зуучлалын үйлчилгээ үзүүлэх зохицуулалтын судалгаа, токенжуулсан үнэт цаасны зохицуулалт олон улсад, ногоон зээлийн баталгаажуулалт, барилгын заавал даатгалын зохицуулалт зэрэг судалгааны ажил багтсан. Мөн бичил санхүүгийн салбар дахь финтек зээлийн зохицуулалт, үнэт цаасны андеррайтер, брокер дилерийн компанийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, санхүүгийн хяналт шалгалт дахь технологийн хэрэглээ, хадгаламж зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, санхүүгийн хүртээмжийн болон санхүүгийн эрүүл мэндийг хэмжих түүвэр судалгааг хүргэж байна. Эдгээр судалгаа нь цаг үеийн онцлог болон тулгамдаж буй асуудлыг хөндсөн бөгөөд уншигч таны ажилд хувь нэмэр оруулж бодлогын шийдвэр гаргахад үндэслэл, харгалзах хүчин зүйл болно гэдэгт итгэлтэй байна. Эцэст нь судалгааны талаарх санал, дүгнэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлбэл бид талархаж, Таны үнэтэй саналыг дараа, дараагийн судалгааны ажилдаа тусгах болно.

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН ЧАДАМЖ, САНХҮҮГИЙН БОГИНО ХУГАЦААНЫ ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ АНХ УДААГАА ҮНЭЛЛЭЭ

Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийг хэмжих, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх түүвэр судалгааг Санхүүгийн зохицуулах хорооны захиалгаар “Эн Ар Си Си”, “Эм Эм Си Жи” ХХК–ууд хийлээ. Энэхүү түүвэр судалгаа нь иргэдийн санхүүгийн чадамж, санхүүгийн богино хугацааны хүндрэлийг даван туулах, бие даасан шийдвэр гаргах чадварыг үнэлэхээр Монгол Улсад анх удаагаа хийснээрээ онцлогтой бөгөөд санхүүгийн үйлчилгээ, тэр дундаа хөрөнгийн зах зээл, даатгал, бичил санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг судлахад чиглэсэн юм.

Судалгааны үр дүнгээс товч танилцуулбал, Монгол Улсын иргэдийн санхүүгийн эрүүл мэндийн дундаж индекс 54 гарсан байна. Үүнээс санхүүгийн эрүүл мэндийн индексийн нэг бүрдэл болох нөөцийн хүртээмжийн индекс



39, санхүүгийн төлөв байдлын индекс 45, санхүүгийн мэдлэгийн индекс 53, иргэдийн санхүүгээ удирдах, төлөвлөх чадварыг илэрхийлэх санхүүгийн зан төлөвийн индекс 59 гарчээ. Энэ нь иргэд богино хугацааны санхүүгийн дарамтад өртөх эрсдэлтэй төдийгүй тэдний орлогын болон эх үүсвэрийн найдвартай байдал харьцангуй бага түвшинд байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл иргэд санхүүгийн суурь ойлголтуудын талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй хэдий ч зарим шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа аж. Түүнчлэн судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 4.4 хувь нь брокер, дилерийн компаниудын үйлчилгээг авдаг бол банк бус санхүүгийн байгууллагын үйлчилгээний хүртээмж 36 хувь, сайн дурын даатгал 24.4 хувь, мөнгөн зээлийн үйлчилгээ 20 хувь, хадгаламж зээлийн хоршооны хүртээмж 3.6 хувь гарсан байна.

КОМПЛАЙНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР ХЭЛЭЛЦЛЭЭ

Компанийн засаглалын тогтолцоо, комплаинсыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь аливаа компанийн урт хугацааны тогтвортой хөгжил цаашлаад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангагч суурь нөхцөл юм. Иймд Санхүүгийн зохицуулах хороо санхүүгийн салбарын комплаинсын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, комплаинсын эрсдэлийг үр дүнтэй удирдах, байгууллагын соёлыг бий болгох, түүнийг хэвшүүлэх зорилтын хүрээнд нэлээдгүй ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд үүний нэг болох “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, комплаинсын эрсдэлийн удирдлага нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Даатгагч, банк бус санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын менежментийн компани, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 80 гаруй төлөөлөл оролцсон энэ удаагийн хэлэлцүүлгээр “Компанийн засаглалын кодекс”-



ийн хэрэгжилт, комплаинсын эрсдэлийн үнэлгээ, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, шийдэл ба боломжууд, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцэв.

Хэлэлцүүлэгт оролцогчид компанийн засаглалын зохицуулалтын орчин, ялангуяа кодекс болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг манай орны туршлага, бусад орны сайн жишигт нийцүүлэн тогтмол боловсронгуй болгох зорилгоор тулгарч буй асуудал, бэрхшээлийг шийдвэрлэхэд үр дүнтэй мөн гарц, шийдэл бүхий



хэлэлцүүлгийг цаашид тогтмол зохион байгуулах хүсэлтээ энэ үеэр илэрхийлсэн юм.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

**ЗАЛИЛАНД БҮҮ ӨРТ
ЗАНГАНД БҮҮ ОР**

АШИГ АМААСАН САНХҮҮГИЙН
ЛҮЙВРААС БОЛГОМЖИЛ!

ЗААВАЛ УНШИХ МЭДЭЭЛЭЛ QR КОДОО УНШУУЛААРАЙ

ЯРИЛЦЛАГА

“ШИНЭ ХОРШОО ХӨДӨЛГӨӨН”-ИЙ ХҮРЭЭНД ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ХЭМЖЭЭ НЭМЭГДЭЖ БАЙНА

Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааны талаар Банк бус санхүүгийн байгууллагын газрын бодлогын чиглэлийн ахлах мэргэжилтэн Б.Анужинтай ярилцлаа.

Сайн байна уу. Зээлийн батлан даалтын сангийн хууль, эрхзүйн орчинд орсон өөрчлөлт болон үйл ажиллагааных нь талаар сүүлийн үеийн мэдээллээс ярилцлагаа эхлүүлье. Энэ талаар та мэдээлэл өгөхгүй юу?

Б.Анужин: Монгол Улсын Их Хурлаас анх 2012 онд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж үүнээс хойш нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг. Хамгийн сүүлд 2024 оны 4 дүгээр сард Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргахаар нэмэлт өөрчлөлт оруулсан байдаг. Үүний дагуу мөн Санхүүгийн зохицуулах хорооноос “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д холбогдох өөрчлөлтийг хийж, хууль журмын хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Энэ хүрээнд сангийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, сангийн нийт хөрөнгийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн байдлаар 305.2 тэрбум төгрөг давсан бол тус онд батлан даасан зээлдэгчдийн тоо 13,261-д хүрч өмнөх онтой харьцуулахад 42 дахин өсөж, батлан даасан нийт зээлийн үлдэгдэл 768.7 тэрбум төгрөгт, батлан даалтын эцсийн үлдэгдэл 441.0 тэрбум төгрөгт тус тус хүрээд байна.

Зөвхөн батлан даалтад хамрагдсан зээлдэгчдийн тоог сонсоход үйл ажиллагаа нь хэр өргөжиж байгаа нь мэдэгдэж байна. Тэгвэл энэ талаар дэлгэрүүлж ярилцъя. Энэ өсөлтөд нөлөөлж байгаа хамгийн гол хүчин зүйл юу байна вэ?

Б.Анужин: Тэгэлгүй яах вэ. Мэдээж хуульд нэмэлт өөрчлөлт орж Хоршооны гишүүн малчдад олгосон зээлийг батлан дааж байгаатай холбоотой сангийн хөрөнгө, батлан даалтын хэмжээ эрс нэмэгдэж байна. Зөвхөн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршооны гишүүн малчдын зээлд гаргасан батлан даалттай холбоотой тоо статистикаас дурдвал 2024 онд 11,977 малчны зээлийг сангаас батлан даасан нь энэ онд батлан даасан зээлийн 90 хувийг дангаараа эзэлж байна. Мөн 2024 онд шинээр батлан даасан зээлийн 63 хувийг, батлан даалтын дүнгийн 78 хувийг Хоршооны гишүүн малчдын зээлд гаргасан батлан даалт бүрдүүлж байна.

Зээлийн батлан даалтын санд жижиг дунд бизнес эрхлэгчид хэр хамрагдаж байгаа вэ?

Б.Анужин: Зээлийн батлан даалтын сангийн гол зорилго нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийг батлан дааж замаар тэдгээрийн санхүүгийн эх үүсвэр татах боломжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь дэмжих явдал юм. 2024 онд гэхэд шинээр 166 хуулийн этгээдэд 57.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба нийт дүнгээрээ одоогийн байдлаар 452 хуулийн этгээдийн 219.3 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд 117.6 тэрбум төгрөгийн батлан даалт байна. Эдгээр батлан даалт нь ихэвчлэн бөөний болон жижиглэн худалдааны бизнес эрхлэгчдэд гаргасан батлан даалт байгаа тул эдийн засгийн бусад салбарт тэр дундаа нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, боловсруулах үйлдвэрлэлийн

үйл ажиллагаа эрхэлдэг бизнес эрхлэгчдэд батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж харж байна.

2021 онд Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд ипотекийн зээлд батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотой одоогийн байдлаар ипотекийн зээлд гаргасан хэр хэмжээний батлан даалт байгаа вэ? Мөн орон нутагт гаргасан ипотекийн зээлийн батлан даалтын хүртээмж ямар байна вэ?

Б.Анужин: Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2021 онд тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 2023 оноос улсын 21 аймаг, Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай этгээдэд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргасаар байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 1,309 этгээдийн 140.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээлд 26.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба үүний 88 хувь нь 2024 онд гаргасан батлан даалт байна. Орон нутагт гаргасан ипотекийн зээлийн батлан даалтыг бүс нутгийн хэмжээнд авч үзвэл хангайн бүсэд хамгийн их буюу 563 зээлдэгчид 11.6 тэрбум төгрөгийн, баруун бүсэд хамгийн бага буюу 169 зээлдэгчид 3.5 тэрбум төгрөгийн батлан даалтыг тус тус гаргасан байна. Харин Улаанбаатар хотод 24 зээлдэгчийн 2.5 тэрбум төгрөгийн зээлд 488.5 сая төгрөгийн батлан даалт гаргажээ. Үүнээс харвал ипотекийн зээлийн батлан даалт нь орон нутгийн түвшинд харьцангуй хүртээмжтэй байгаа ба Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийг дэмжиж, төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах ажлыг эрчимжүүлж, банк санхүүгийн байгууллагын эрсдэлийг тодорхой түвшинд бууруулахад Зээлийн батлан даалтын сангийн зүгээс тодорхой хувь нэмрийг оруулж байна гэж дүгнэж байна.

Зээлийн батлан даалтын сангийн чанарын үзүүлэлт, зээлийн эргэн төлөлт ямар байгаа вэ?

Б.Анужин: Өнөөдрийг хүртэлх хугацаанд Зээлийн батлан даалтын санд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар нийт 8.3 тэрбум төгрөгийг нэхэмжилж, сангаас 7.6 тэрбум төгрөгийн үүргийг гүйцэтгэж эргээд зээлдэгчдээс 1.3 тэрбум төгрөгийн авлагыг төлүүлсэн байна. Харин сангийн чанарын үзүүлэлтийг харвал 2024 оны жилийн эцсийн байдлаар сангаас батлан даасан нийт зээлийн багцын 97.3 хувь, нийт батлан даалтын 97.8 хувь нь хэвийн ангилалтай байна. Гэсэн хэдий ч сангаас батлан даасан зээлүүд нь харьцангуй өндөр дүнтэй, урт хугацаатай учир цаашдаа ч бас зээлийн эргэн төлөлтөд анхаарч зээлийн чанарыг сайжруулах нь чухал юм.

Тэгэхээр Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар бидэнтэй хуваалцаач.

Б.Анужин: Одоогийн байдлаар Зээлийн батлан даалтын сантай 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй байна. Сүүлийн хэдэн жил зээлийн үйл ажиллагааны зах зээлд банк бус санхүүгийн байгууллагын салбарын эзлэх хувь эрчимтэй нэмэгдсээр байгаа. Тиймээс Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах банк бус санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллахаар төлөвлөөд байна. Мөн дэлхий нийтийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, хүрээлэн буй орчноо хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхтэй холбоотой Тогтвортой санхүүгийн үндэсний замын зурагт заасны дагуу ногоон батлан даалтын бүтээгдэхүүн хөгжүүлж, зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Зээлийн батлан даалтын сан, банк, банк бус санхүүгийн байгууллага, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр эрчимтэй ажиллах хэрэгтэй гэж харж байна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

ЖЕНДЕРИЙН БОНД

Жендерийн бонд гэж юу вэ?

Жендерийн бонд нь тодорхой зорилтот бүлэг буюу охид, эмэгтэйчүүдийн боловсрол, эрүүл мэнд, эдийн засгийн оролцоог дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд ашигладаг өрийн хэрэгсэл бөгөөд жендерийн тэгш байдлыг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийг татан төвлөрүүлэх шинэлэг арга хэрэгсэл юм. Энэхүү санхүүгийн хэрэгсэл нь жендерийн тэгш байдлыг хангах зорилтуудыг хэрэгжүүлэх, тогтвортой хөгжлийг дэмжих, эмэгтэйчүүдийн ажлын байрны оролцоог нэмэгдүүлэх, бизнес эрхлэлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жендерийн бондын гол үзэл баримтлал нь санхүүгийн эх үүсвэрийг өрийн хэрэгслээр дамжуулан эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендерийн ялгааг арилгахад хувь нэмрээ оруулах төслүүдийг санхүүжүүлэхэд оршино.

Жендерийн бондын уламжлалт бондоос ялгагдах гол зүйл нь бондын орлого эмэгтэйчүүдийг чадавхжуулах, жендерийн тэгш байдлыг хангах, ядуурлаас ангижруулах, санхүүгийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бизнес эрхлэлт, олон нийтийн хөгжил зэрэг янз бүрийн салбарын эмэгтэйчүүдэд ашигтай төсөл, санаачилгуудад тусгайлан чиглүүлдэг. Нэг ёсондоо жендерийн бонд нь жендерийн асуудлыг санхүүгийн орчинд нэгтгэж, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх онцгой боломжийг олгодог.

Түүнчлэн, стратегийн нэн тэргүүний зорилт болох жендерийн тэгш байдлыг эрхэмлэдэг байгууллагуудад шинэ нөөцийг чиглүүлэхэд тусалдаг. Энэхүү санхүүгийн дэмжлэг нь эдгээр байгууллагуудад хүртээмж, үр нөлөөгөө өргөжүүлэх боломжийг олгож, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид болон өгөөж хүртэгчдийн хамтын ажиллагааг идэвхжүүлдэг. Энэ нь жендертэй холбоотой сорилтуудыг хүлээн зөвшөөрч, шийдвэрлэх дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын ертөнцийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна.

Жендерийн бондын ач холбогдол

- ◆ **Эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх:** Эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог сайжруулснаар улс орнуудын ДНБ-ий өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг. Судалгаагаар эмэгтэйчүүдийн

эдийн засгийн оролцоо 10%-аар нэмэгдсэн тохиолдолд эдийн засгийн өсөлт 1-2%-аар нэмэгдэх боломжтой гэж үздэг (Дэлхийн банк, 2020).

- ◆ **Нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх:** жендерийн тэгш байдлыг дэмжсэн төслүүд нь боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, жендерийн ялгаварлалыг бууруулахад тусалдаг.
- ◆ **Хариуцлагатай хөрөнгө оруулалт:** жендерийн бонд нь тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорьдог бөгөөд хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж буй хөрөнгө оруулалтын шинэ чиглэл болж байна.

Жендерийн бондын санхүүжилт бий болсноор ямар зорилтот бүлэг өгөөж хүртэх вэ?

- ◆ **Эмэгтэйчүүдийн удирддаг эсвэл, эзэмшдэг компаниуд:** жендерийн бонд нь эмэгтэйчүүдийн удирддаг эсвэл эзэмшдэг компаниудын санхүүжилтийн чухал эх үүсвэр болдог. Үүнд эмэгтэй бизнес эрхлэгчид чухал үүрэг гүйцэтгэдэг янз бүрийн салбар дахь бизнесүүд орох ба эдгээр байгууллагуудад бондын зарцуулалтыг чиглүүлснээр бизнес эрхэлдэг эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурь, эдийн засгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх боломжийг олгодог.
- ◆ **Ажлын байран дахь жендерийн тэгш байдлыг дэмжин ажилладаг компаниуд:** жендерийн бондын ашиг тусыг хүртэх өөр нэг бүлэг бол байгууллагынхаа бүтцэд жендерийн тэгш байдлыг дэмжих чиглэлээр идэвхтэй ажилладаг компаниуд юм. Энэ нь цалингийн ялгааг арилгах, ажил мэргэжлийн хувьд өсөх дэвших, тэгш боломжоор хангах, бүх хүйсийг хамарсан, дэмжсэн ажлын орчныг бүрдүүлэх санаачилгыг хамарч болно.
- ◆ **Эмэгтэйчүүдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлж буй компаниуд:** Энэ нь эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг сайжруулах бүтээгдэхүүн,

үйлчилгээг хөгжүүлэхэд анхаардаг компаниудыг мөн дэмждэг. Эрүүл мэнд, боловсрол, технологи эсвэл бусад салбараас үл хамааран жендерийн бондын хөрөнгийг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан эмэгтэйчүүдийн сайн сайхан байдлыг сайжруулах, эрх мэдлийг нэмэгдүүлэх төслүүдэд чиглүүлж болно.

Жендерийн бондын зарчим

Жендерийн бонд гаргагчид Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбоо (ICMA)–оос Нийгмийн бондын зарчмуудад заасан стандартыг баримталдаг. Ил тод, хариуцлагатай байдлыг хангах зорилготой эдгээр зарчмууд нь үнэт цаас гаргагчид дагаж мөрдөх дөрвөн үндсэн хэсгээс бүрдэнэ.



1. **Орлогын ашиглалт.** Эхний бүрэлдэхүүн хэсэг нь жендерийн бондын орлогыг хэрхэн ашиглах талаар тодорхой болгохыг шаарддаг бөгөөд үнэт цаас гаргагчид бондын орлогыг жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, холбогдох санаачилгад чиглэсэн төслүүдэд хэрхэн хуваарилах, чиглүүлэх талаар тодорхой төлөвлөгөө гаргах ёстой.



2. **Төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтын үйл явц.** Үнэт цаас гаргагчид жендерийн бондын зорилгод нийцсэн төслүүдийг үнэлэх, сонгох талаарх үйл явцыг тодорхой болгох үүрэгтэй. Энэ нь сонгогдсон төслүүд жендерийн тэгш байдлыг хангах, нийгмийн холбогдох асуудлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулж байгаа эсэхийг шалгах цогц үнэлгээг хамарна.



3. **Орлогын менежмент.** Үнэт цаас гаргагчид бондын зорилгод нийцүүлэн хөрөнгийг хянах, удирдах арга хэмжээг хэрэгжүүлэх ёстой. Энэ нь санхүүгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу ашиглаж, нийгэмд эерэг нөлөө үзүүлэхийг баталгаажуулдаг.



4. **Тайлагнах.** Үнэт цаас гаргагчид орлого ашиглалтын талаар хэрхэн хуваарилсан, санхүүжүүлсэн төслүүдийн явц, нийт үр нөлөөг нарийвчлан тусгасан иж бүрэн тайлан тогтмол гаргаж байх шаардлагатай. Эдгээр тайлангууд нь хөрөнгө оруулагчид болон зах зээлд итгэлцлийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Түүнчлэн, ICMA–ийн бондын зарчмуудад дурдсанаар бонд гаргагчид бондын зарцуулалт зориулалтын дагуу явж буй, мөн тогтоосон стандартыг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хоёрдогч талын үнэлгээ хийлгэж, тэдний дүгнэлтийг авах ёстой. Энэхүү хөндлөнгийн баталгаажуулалт нь хөрөнгө оруулагчид болон зах зээлд нэмэлт баталгаа болж өгдөг.

Эх сурвалж: Vladislava Sabanova, 2024. "Gender bond", Available at: <https://cbonds.com/glossary/gender-bond/>

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС










ТУЗ–ИЙН 2025 ОНД АНХААРАХ 5 СОРИЛТ

АНУ болон даяарчлалын бизнесийн орчинд урьдчилан тааварлах боломжгүй, тодорхой бус үзэгдлүүд нэгэн зэрэг тохиолдох нь ховор. Гэвч хиймэл оюун ухаанд тулгуурласан инноваци нь шинэ боломжуудыг нээж, эдийн засгийн өсөлтийг хурдасгах бизнесийн итгэл үнэмшлийг нэмэгдүүлснээр IPO болон нэгдэх, нийлэх үйл ажиллагаа (M&A) сэргэх хандлагатай болов. Үүнтэй зэрэгцэн АНУ–ын Засгийн газрын бодлогын шинэчлэл, тухайлбал гаалийн татварын бодлогын өөрчлөлтөөс хамааралтай инфляцийн эрсдэл эргэн ирж болзошгүй бөгөөд геополитикийн тогтворгүй байдал үргэлжлэх төлөв ажиглагдаж байна.

Иймд хурдацтайгаар хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд компанийг урт хугацаанд амжилттай байлгахын тулд ТУЗ нь 2025 онд байгууллагын засаглалаа тэнцвэржүүлэх хэд хэдэн сорилттой тулгарч болзошгүй. Корпорацийн захирлуудын үндэсний холбоо (NACD)–ноос 2024 оны 10 дугаар сарын 21–нээс 11 дүгээр сарын 14–ний хооронд хийсэн судалгаагаар 2025 оны тэргүүлэх чиг хандлагын талаарх захирлуудын үзэл бодлыг тусгажээ.

2025 оны тэргүүлэх чиг хандлага

Зураг. Судалгаанд оролцогчид тав хүртэлх чиг хандлагыг сонгох боломжтой байснаас хамгийн их сонгогдсон 10 чиг хандлагыг дор харуулав

	Эдийн засгийн нөхцөл байдал	51%
	Зохицуулалтын шаардлага	46%
	Кибер аюулгүй байдал	41%
	Ур чадварын өрсөлдөөн	37%
	Геополитикийн тогтворгүй байдал	31%
	Хиймэл оюун ухаан	30%
	Бизнес загварын өөрчлөлт	29%
	Инфляцийн өсөлт	28%
	Технологийн өөрчлөлт	27%
	Цочролыг даван туулах	27%

Эх сурвалж: 2025 оны NACD–ийн тэргүүлэх чиг хандлагын судалгаа

Эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдал: “Эдийн засгийн нөхцөлийн өөрчлөлт” гэх чиг хандлага судалгаанд оролцогчдын дунд хамгийн ихээр сонгогджээ. Энэ нь голчлон “геополитикийн тогтворгүй байдал”-аас үүдэлтэй ба хоёул эхний таван чиг хандлагад багтжээ. Сонгуулийн кампанит ажлын амлалтуудад үндэслэн АНУ-ын ерөнхийлөгчөөр сонгогдсон Дональд Трампын хоёр дахь бүрэн эрхийн хугацаанд баримталж буй эдийн засгийн протекционист бодлого (хамгаалалтын эдийн засгийн бодлого) нь холбоотнууд болон өрсөлдөгчидтэйгөө харилцах харилцаанд өөрчлөлт оруулах төлөвтэй байна.

Эдгээр өөрчлөлтийн мөн чанар, цар хүрээ хараахан тодорхой бус бөгөөд 2025 оны анхаарлын төвд байх аж. Түүнчлэн, АНУ-ын эдийн засаг 2025 оны дунд үе гэхэд мөчлөгийн ямар үе шатанд орох төлөвтэй байна вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 10 хүрэхгүй хувь нь “эдийн засгийн уналт” гэж хариулжээ.

Хиймэл оюун ухаан хөгжүүлэлтээс үүдэлтэй кибер аюулгүй байдлын асуудал: Судалгаанд оролцогчдын 41 хувь нь кибер аюулгүй байдлын заналхийлэл бол голлох чиг хандлага гэж тодорхойлсон бөгөөд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх үйл явц маш хурдасч байгаагаас улбаалан кибер аюулгүй байдлын хэрэгцээ, шаардлага улам бүр өсч байна. Судалгаанд оролцогч “Компаниуд шинэ хиймэл оюун ухааны технологийг ашиглахын зэрэгцээ хэрэглэгчдийн итгэлийг олж, тэр хэрээр өсөн нэмэгдэж буй аюул заналхийллийн эсрэг кибер хамгаалалтыг бэхжүүлэх ёстой” бөгөөд энэ нь нөгөө талаас компанийн удирдлагуудын хиймэл оюун ухааны хурдацтай дэвшилтэй хөл нийлүүлэн алхах, эрсдэлийг ойлгох чадварыг сорьж байгаа талаар дурджээ. Мөн судалгаанд оролцогчдын нэг хэлэхдээ, “ихэнх ТУЗ-ийн гишүүд технологитой холбоотой асуудлыг ойлгодоггүй, улмаар ажлаасаа салахаас болгоомжлон” технологитой холбоотой шийдвэрүүдийг гаргах үйл явцад оролцохоос зайлсхийж, эдгээр шийдвэрийг бусад цөөн тооны гишүүдэд даатгах эрсдэлийг бий болгож байна” гэв.

Түүнчлэн өөр нэг оролцогч “технологийн мэдлэг нь санхүүгийн мэдлэгтэй адил чухал болж байгаа тул ТУЗ-ийн сургалт, хөгжлийн нэг хэсэг гэж үзэх ёстой” гэсэн байна. NACD-ийн судалгааны үр дүнгээс харахад эдгээр шинэ сорилтуудыг ТУЗ-ийн гишүүд аль хэдийн хүлээж зөвшөөрч байгаа бөгөөд судалгаанд оролцогчдын 78 хувь нь хиймэл оюун ухааны технологийг ямар нэг байдлаар туршиж үзсэн байв.

Бизнесийн шинэ загварууд нь шинэ ур чадварт хөтөлдөг: Санал асуулгад оролцогчдын 37 хувь нь “ур чадварын төлөөх өрсөлдөөн”-ийг гол чиг хандлага гэж онцолж, тэрээр дөрөвдүгээр байрт орсон байна. Энэхүү чиг хандлагын үндэс нь “технологийн өөрчлөлт” ба түүнээс үүдэлтэй “бизнесийн загварын өөрчлөлт” гэснийг судалгаанд оролцогчдын 27 болон 29 хувь нь тус тус сонгожээ. Компаниуд бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнийг хэрхэн тодорхойлж, хэрэглэгчид хүргэх талаар дахин бодож, сүүлийн жилүүдэд дижитал шилжилтээс үүдэлтэй шинэ боломжуудыг ашиглахын тулд технологийн томоохон хөрөнгө оруулалтыг хийж байна.

Дээр дурдсан өөрчлөлтүүд нь ур чадварын эрэлт, хэрэгцээнд нөлөөлж байгаа бөгөөд “Технологи өөрчлөгдөхийн хэрээр ур чадварын эрэлт, хэрэгцээ өөрчлөгдөж байна” хэмээн судалгаанд оролцогчдийн нэг дурдсан нь мэргэшсэн ур чадварын төлөөх өрсөлдөөнийг тодотгожээ. Түүнчлэн, хувьсаж буй технологи нь “уламжлалт ажлуудыг бага хөдөлмөр зарцуулж, аюулгүйгээр гүйцэтгэх шинэ арга замыг санал болгодог” гэжээ.

Цочролыг даван туулах: Эдгээр хоорондоо уялдаа холбоотой чиг хандлагууд нь харилцан нэгнийгээ идвэхжүүлж, компаниудад шуурхай хариу арга хэмжээ авах шаардлагатай нөхцөл байдлыг үүсгэж байна. Судалгаанд оролцогчдын бараг тал нь (48) хямралын нөхцөл байдал таван жилийн өмнөхтэй харьцуулахад их тохиолдсон гэж үзэж байгаа бол талаас илүү хувь нь (52) ийм нөхцөл байдал ноцтой байгаа гэжээ. Энэхүү хямралын нөхцөл байдалд компанийн ТУЗ-үүд өндөр эрсдэлтэй шийдвэр гаргах, шинэ асуудлуудтай нүүр тулж, уян хатан стратеги боловсруулахад анхаарах шаардлагатай.

Судалгааны оролцогчид эрхэм зорилгодоо хүрэхийн тулд өөрчлөлтийн хурдтай мөр зэрэгцэх ёстой гэдгийг хэдийн хүлээн зөвшөөрч байгааг илэрхийлэв. Тодруулбал, санал асуулгад оролцогчдын дийлэнх нь .. стратеги боловсруулалт, кибер аюулгүй байдлын хяналт, эрсдэлийн удирдлагад ТУЗ-ийн зүгээс тавих хяналтыг сайжруулах нь чухал гэж үзжээ.

Компанийн ТУЗ-үүд ирэх оны тэргүүлэх зорилтуудын нэг нь үйл ажиллагаагаа сайжруулах явдал гэж үзэж байгаа бөгөөд шийдвэр гаргалт, асуудлыг хэлэлцэхэд мэдээллийн ил тод байдал, ТУЗ-ийн залгамж халааг төлөвлөхөд илүү анхаарч байна.

Үргэжлэл бий..

ФИНТЕК БА РЕГТЕК

ШИЛДЭГ 10: 2025 ОНЫ ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГЫН ТААМАГ

Сэтгүүлийн шинэ оны эхний дугаараар та бүхэндээ 2025 онд финтекийн салбарыг тодорхойлох гол өөрчлөлт, хөгжлүүдийг хүргэхээр бэлтгэлээ. 2025 онд хиймэл оюун ухаан, тогтвортой хөгжил, хэрэглэгчдийн өөрчлөгдөж буй хэрэгцээнүүд финтекийн салбарт хэрхэн хувьсал авчирч байгааг олж мэдэх болно. Мөн хөрөнгө удирдлагаас эхлээд төв банкны дижитал валют (CBDC), автоматжуулсан банкны үйлчилгээнүүд хүртэл өргөн хүрээг хамарсан өөрчлөлтүүд биднийг хүлээж байна. Энэхүү мэдээллийг Fintech magazine-аас эрхлэн гаргадаг ШИЛДЭГ 10 нийтлэлийн хүрээнд бэлтгэв.

10. Хөрөнгө оруулалтын технологи (WealthTech)

2025 онд хөрөнгө оруулалтын технологийн салбар маш хурдацтай өсөх төлөвтэй байна. Хиймэл оюун ухаан болон хувь хүнд тохирсон шинэ үйлчилгээ нь хөрөнгө удирдлагыг илүү ухаалаг, хялбар болгох болно. Жишээлбэл: хиймэл оюун ухаанаар удирдагддаг хөрөнгийн багцын зохион байгуулалт (портфолио), татварыг автоматаар оновчтой болгох системүүд улам бүр хөгжиж, өдөр тутмын аппликэйшнд хөрөнгө удирдлагын үйлчилгээг нэгтгэх боломж нэмэгдэнэ.

Betterment гэх мэт робо зөвлөх үйлчилгээний тэргүүлэгч платформтой компаниуд, мөн Addepar шиг хөрөнгийн мэдээллийг гүнзгий шинжилдэг компаниуд энэ шинэчлэлийн гол тоглогчид болж байна.

Мянганыхан болон Z үеийн залуус дижитал хөрөнгө удирдлагыг илүүд үзэж, нээлттэй банкны технологийг өргөнөөр ашиглаж эхэлж байгаа нь энэ салбарыг улам хурдан хөгжүүлж байна.

9. Тогтвортой болон Ногоон Финтек

2025 онд ногоон финтек тогтвортой санхүүгийн салбарт хувьсал авчирна. Нүүрстөрөгчийн ул мөрийг хянах функц банкны аппликэйшн болон төлбөрийн системд хялбархан нэвтрэх болно. Ахисан түвшний ESG (байгаль орчин, нийгэм, засаглал) шинжилгээ болон блокчэйнд суурилсан нүүрстөрөгчийн кредит арилжааны платформууд нь байгаль орчинд үзүүлэх нөлөөг илүү нарийн хэмжих боломжийг бүрдүүлнэ.

Aspiration компанийн уур амьсгалд ээлтэй банкны үйлчилгээ, Clarity AI-ийн хиймэл оюун ухааныг ашигласан ESG шинжилгээ зэрэг нь энэ хувьслыг тэргүүлж байна.

Энэхүү салбарын өсөлтийг илүү хатуу зохицуулалтын

шаардлага, мөн дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн ил тод, байгальд ээлтэй санхүүгийн үйлчилгээг хүсэх хэрэглэгчдийн эрэлт улам хурдсаж байна.

8. "Одоо аваад, дараа төл" (BNPL)

2025 онд "Одоо аваад, дараа төл" (BNPL) үйлчилгээний салбар өсөж, сайжруулсан зээлийн үнэлгээний загвар болон зохицуулалтын хяналт нь салбарыг шинэчилнэ. Нээлттэй банкны интеграци нь хэрэглэгчдийн төлбөрийн чадварыг илүү нарийвчлалтай шалгах боломжийг олгоно. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан эрсдэлийн үнэлгээний систем нь зээл эргэн төлөхгүй байх эрсдэлийг бууруулахад тусална.

Салбарын тэргүүлэгч Klarna компани "супер худалдан авалтын апп"-ын шинэчлэлээрээ тэргүүлж байгаа бол Block компани Afterpay компанийг нэгтгэснээр байр сууриа улам бэхжүүлж байна.

Энэхүү салбар улам хөгжихийн хэрээр компаниуд нэгдэж, санхүүгийн зохицуулагчдын хяналт нэмэгдэж байгаа тул илүү хариуцлагатай зээл олгоход анхаарах болно.

7. Зохицуулалтын технологи (Regtech)

2025 онд санхүүгийн байгууллагууд зохицуулалтын шаардлагыг илүү үр ашигтайгаар удирдах арга замыг эрэлхийлж, зохицуулалтын технологи (Regtech)-ийн хэрэглээ нэмэгдэх төлөвтэй байна.

Хиймэл оюун ухаан болон машин сургалт нь зохицуулалтын тайлан гаргах, эрсдэлийг хянах үйл явцыг илүү нарийвчлалтай болгоно. Гэсэн ч хэрэгжүүлэх явцад зарим сорилтууд байсаар байна. Natural language боловсруулах технологи нь байгууллагуудад зохицуулалтын шинэчлэлүүдийг илүү хурдан ойлгож хэрэгжүүлэхэд тусална. Мөн блокчэйний шийдлүүд нь хэрэглэгчээ таних (KYC) болон гүйлгээг хянах боломжийг сайжруулна.

ComplyAdvantage компани санхүүгийн гэмт хэргийг илрүүлэх платформоо улам боловсронгуй болгож байгаа бол Chainalysis нь криптовалютын зохицуулалтын шийдлээрээ байр сууриа бэхжүүлж байна.

Энэхүү салбарын өсөлтөөс шалтгаалан зохицуулалтын шаардлага нэмэгдэж, байгууллагууд зардлаа бууруулах шаардлагатай болж байгаатай холбон тайлбарлаж болно.

6. Суурилагдсан санхүү (Embedded Finance)

2025 онд Суурилагдсан санхүүгийн үйлчилгээ улам өргөжих төлөвтэй байна. Санхүүгийн бус брэндүүд өөрсдийн үйлчлүүлэгчдийн үйл явцад банкны үйлчилгээ, төлбөр тооцоо, зээл зэрэг санхүүгийн үйлчилгээг нэгтгэх болно.

API-д суурилсан дэд бүтцийн үйлчилгээ үзүүлэгчид энэ үйл явцыг илүү хурдан, зардал багатай болгох боломжийг бүрдүүлж, аппликэйшн доторх даатгал, нөхцөлд нийцсэн зээл зэрэг олон төрлийн үйлчилгээ нэвтрүүлэхийг хөнгөвчилнө.

Stripe Treasury компани банкны үйлчилгээний шийдлүүдээ өргөжүүлж, Plaid компани мэдээллийн холболтын илүү сайжруулсан шийдлүүдээр байр сууриа бататгаж байна.

Энэ салбарын өсөлт нь хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээг өөрсдийн дуртай дижитал платформуудаар дамжуулан хурдан, хялбар авах гэсэн хүлээлттэй уялдаж байна.

5. Төв банкны цахим валют (CBDCs)

2025 онд төв банкны цахим валютууд (CBDCs) туршилтын хөтөлбөр, төслүүдийнхээ хүрээнд хөгжсөөр байх болно. Хятадын Дижитал Юань дотооддоо хэрэглээгээ өргөжүүлж байгаа бол Европын Төв Банк дижитал евро төслөө хяналттай туршилтын үе шатуудаар урагшлуулж байна.

G+D (Giesecke+Devrient) зэрэг төлбөрийн технологи нийлүүлэгчид CBDC дэд бүтцийн хөгжүүлэлтээ бэхжүүлж, R3-ийн Corda платформ нь төв банкнуудын олон туршилтыг дэмжсээр байна.

Эдгээр хөгжүүлэлт удаан боловч тогтвортой явж байгаа бөгөөд төв банкнууд санхүүгийн тогтвортой байдал, нууцлал болон уламжлалт банкны системд үзүүлэх нөлөөллийн асуудлуудыг зохицуулахыг зорьж байна.

4. Кибер аюулгүй байдал ба Биометр

2025 онд санхүүгийн байгууллагууд нарийн төвөгтэй кибер халдлага, залилан мэхлэлттэй тэмцэхийн тулд кибер аюулгүй байдал, биометрийн баталгаажуулалтыг илүү чухалчилна.

Олон төрлийн биометрт суурилсан шийдлүүд жишээлбэл: нүүр царай таних технологийг зан төлөвийн хэв маягтай хослуулах нь нэвтрэх үйл явцыг илүү найдвартай болгоно. Мөн хиймэл оюун ухаанд суурилсан аюулыг илрүүлэх системүүд шинээр гарч ирэх халдлага нь урьдчилан танихад тусална.

OneSpan компани гар утасны аюулгүй байдал баталгаажуулалтын шийдлүүдээ сайжруулж, BioCatch компани биометрийн салбарт байр сууриа бэхжүүлж байна.

Энэ салбарын хурдацтай өсөлтийг даган нэмэгдэж буйн кибер

аюул занал, илүү найдвартай баталгаажуулалт хийхийг шаардсан зохицуулалтын хэм хэмжээ мөн хэрэглэгчдийн аюулгүй, төвөггүй банкны үйлчилгээг хүсэх эрэлт хэрэгцээнд суурилж байна.

3. Төвлөрсөн бус санхүү (DeFi) ба Нээлттэй банк

2025 онд төвлөрсөн санхүү болон төвлөрсөн бус системүүд илүү ойр хамтран ажиллаж төвөгтэй орчинд шинэ зам нээх төлөвтэй байна. DeFi-ийн программчлалын уян хатан байдал болон нээлттэй банкны зохицуулалтын шаардлагыг хослуулсан эрлийз шийдлүүд зээл, хөрөнгийн токенжуулалт зэрэг салбарт өргөнөөр нэвтэрнэ.

Aave Protocol нь уламжлалт санхүү болон төвлөрсөн бус санхүүг холбосон институцийн шийдлүүдээ хөгжүүлсээр байгаа бол TrueLayer нээлттэй банкны дэд бүтцээ олон зах зээлд өргөжүүлж байна.

2. Робот процессын автоматжуулалт (RPA)

2025 онд санхүүгийн салбар дахь робот процессын автоматжуулалт (RPA) энгийн ажлуудыг автоматжуулснаар илүү нарийн шийдвэр гаргах үйл явцыг хиймэл оюун ухаантай ботууд гүйцэтгэх түвшинд хүрнэ. Жишээлбэл: энэ нь нэхэмжлэлийн боловсруулалт болон зээлийн үнэлгээнд ашиглагдана.

Ухаалаг баримт боловсруулалт нь бүтэцгүй санхүүгийн баримтаас мэдээлэл гаргаж авах, баталгаажуулах явцыг илүү нарийвчлалтай болгоно. UiPath дэвшилтэт танин мэдэхүйн автоматжуулалтын чадамжаараа тэргүүлсэн байр сууриа хадгалж байгаа бол Blue Prism нь cloud суурилсан ухаалаг автоматжуулалтын шийдлүүдээ сайжруулж байна.

Энэхүү салбарын өсөлтийг ажиллах зардлыг бууруулах, их хэмжээгээр нэмэгдэж буй гүйлгээний хурдыг сайжруулах шаардлага нэмэгдүүлж байна.

1. Хиймэл оюун ухаан (AI) ба Машин сургалт (ML)

2025 он гэхэд хиймэл оюун ухаан (AI) болон машин сургалт (ML) санхүүгийн үйлчилгээнд илүү гүнзгий нэвтэрнэ. Бүтээлч AI нь хэрэглэгчийн үйлчилгээний харилцааг сайжруулж, урьдчилан таамаглах шинжилгээ нь эрсдэлийн үнэлгээ болон залилангийн илрүүлэлтийг илүү үр дүнтэй болгоно.

Large language загварууд нь зохицуулалтын шаардлага биелүүлэх, хөрөнгө оруулалтын судалгаанд туслах бол computer vision технологи баримт бичгийн боловсруулалтыг хурдасгана. H2O.ai санхүүгийн байгууллагуудад зориулсан өндөр түвшний ML шийдлүүдийг нийлүүлж байхад DataRobot автомат машин сургалтын платформоо эрсдэлийн загварчлалд зориулан сайжруулж байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн:

“Эн Ар Си Си” ХХК

ХУРААНГУЙ

Олон улсад санхүүгийн хүртээмжийг нийлүүлэлт тал буюу зохицуулалттай санхүүгийн үйлчилгээний захиргааны мэдээлэлд үндэслэн хэмжих нь хялбар бөгөөд түгээмэл байдаг. Нөгөөтээгүүр нийлүүлэлт талын үзүүлэлтүүд нь бага орлоготой хүмүүс болон жижиг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нарийн хэмжиж чаддаггүй байна. Санхүүгийн хүртээмжийн эрэлт талын цогц үзүүлэлтүүд манай улсад нэлээд хомс байна.

Эн Ар Си Си судалгааны компани Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн эрэлтийн үзүүлэлтүүдийг хэмжих зорилгоор 2024 оны 10 сард Улаанбаатар болон 21 аймгийн санамсаргүй сонгогдсон иргэдээс асуумж судалгаагаар мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна. Судалгааны үр дүнд манай улсад банкнаас бусад санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, хүртээмж банкт харьцуулахад бага гэсэн үр дүн гарлаа. Ялангуяа, хөрөнгийн зах зээл болон хадгаламж, зээлийн хоршооны үйлчилгээнд хамрагдалт бусад санхүүгийн үйлчилгээтэй харьцуулахад эрс бага байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн үзүүлэлтүүд болон санхүүгийн боловсрол хүн амын бүлгээр ялгаатай байна. Орлого багатай эсвэл ажилгүй иргэдийн санхүүгийн хүртээмж муу байгаа бол эмэгтэйчүүдийн болон орон нутгийн иргэдийн санхүүгийн боловсрол доогуур байна.

ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн эрэлт талын үзүүлэлтүүдийг банк болон банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнүүд болох бичил санхүү, даатгал болон хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд цогц байдлаар хэмжихийг зорилоо. Олон улсад санхүүгийн хүртээмжийг нийлүүлэлт талын буюу зохицуулалттай санхүүгийн үйлчилгээний захиргааны мэдээлэлд үндэслэн хэмжих нь хялбар бөгөөд түгээмэл байдаг. Нөгөө талаас нийлүүлэлт талын мэдээлэл нь санхүүгийн хүртээмжийн олон талт байдлыг хэмжиж чадахгүй гэж судлаачид дүгнэдэг (Pesque Cella et al, 2021).

Санхүүгийн хүртээмжийн эрэлт талын цогц үзүүлэлтүүд манай улсад нэлээд хомс байна. Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ) санхүүгийн хүртээмжийн эрэлтийн судалгааг анх 2018 онд (СЗХ, Эн Ар Си Си, 2018), 2021 онд Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи банкны салбарын санхүүгийн хүртээмжийн судалгаа тус тус гүйцэтгэсэн. Эдгээр судалгаануудаас банкны үйлчилгээний хүртээмж өндөр гэж дүгнэжээ.

Монгол Улс банканд данс эзэмшдэг үзүүлэлтээр санхүүгийн хүртээмж сайтай хэдий ч банкны зээлийн бүтээгдэхүүний хэрэглээгээр хөгжлийн хувьд ижил түвшний улсуудтай харьцуулахад доогуур байдаг болохыг санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үндэслэлд дурджээ. Учир нь манай улсад ихэвчлэн арилжааны банкны хадгаламж, зээлийн үйлчилгээгээр үйлчлүүлж хэвшсэн боловч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ), хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ), хөрөнгийн болон даатгалын зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ бага байгааг онцолсон.

Эн Ар Си Си судалгааны компани санхүүгийн хүртээмжийн эрэлт талын үзүүлэлтүүдийг хэмжих асуумжийг Олон улсын санхүүгийн нийгэмлэг (AFI)–ээс гаргасан зааварчилгаа (AFI, 2016) болон СЗХ–той зөвшилцөн боловсруулж, Улаанбаатар болон 21 аймгийн санамсаргүй сонгогдсон 500 иргэдээс уг асуумжийн дагуу мэдээллийг цуглууллаа.

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН ЭРЭЛТИЙН СУДАЛГАА

Санхүүгийн хүртээмжийг хэмжих нь

Санхүүгийн хүртээмж нь бүх иргэн, бизнес эрхлэгчид хөрөнгө чинээ, компанийн хэмжээнээс үл хамааран хэрэгцээ, худалдан авах чадварт нь тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүртэх боломжтой эсэхийг харуулдаг үзүүлэлт юм. Хувь хүмүүс, өрхүүд, бизнес эрхлэгчдийн хуримтлал хийх, зээлэх, төлбөр тооцоо, шилжүүлэг хийх болон эрсдэлээ удирдах үйл ажиллагаанд санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зайлшгүй хэрэгцээтэй байдаг.

Санхүүгийн хүртээмжийг голдуу санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэдэг хүмүүс эсвэл аж ахуйн нэгжүүдийн эзлэх хувиар хэмждэг. Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүрэлцээ ба хэрэглээ нь санхүүгийн хүртээмжийн хоёр чухал хэмжээс бөгөөд санхүүгийн хүртээмж муу байх нь санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хүрэлцээгүй гэсэн үг биш юм. Санхүүгийн хүртээмжид бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт, үнэ зэргээс гадна эрэлт чухал нөлөөтэй хүчин зүйл байдаг. Иймд санхүүгийн хүртээмж доогуур байгаа нь эрэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж байна уу эсвэл нийлүүлэлтийн хүчин зүйлсээс шалтгаалж байна уу гэдгийг тодорхойлох нь санхүүгийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрт чухал ач холбогдолтой.

Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн талаар мэдээ мэдээлэл харьцангуй элбэг байдаг. Учир нь бүтээгдэхүүн үйлчилгээний нийлүүлэлтийн талаарх мэдээлэл захиргааны мэдээллийн санд бүртгэл, татвар зэрэг олон сувгаар хуримтлагдаж байдаг. Тиймээс санхүүгийн хүртээмжийн судалгаануудад нийлүүлэлт талын тоон үзүүлэлтүүдийг түгээмэл ашигладаг.

Pesque Cela et al. (2021) нар санхүүгийн хүртээмжийн судалгаанууд нийлүүлэлт талыг хэмжихэд чиглэсэн хүртээмжийн тоон үзүүлэлтүүдийг илүүтэй ашиглаж байгаа нь санхүүгийн хүртээмжийн олон талт байдлыг хэмжиж чадахгүй байна хэмээн шүүмжилсэн байдаг. Ингэснээр бага орлоготой хүмүүс болон жижиг аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нарийн хэмжиж чаддаггүй.

Эрэлт талын үзүүлэлтүүд хэдий чухал ач холбогдолтой ч эрэлтийн талаарх мэдээлэл, тоон өгөгдөл ялангуяа хөгжиж буй орнуудад ховор хомс байна. Үүнийг шийдэхэд Дэлхийн банк нэгэн чухал алхам хийсэн нь Global Findex датабааз юм. Дэлхийн банк 2011 оноос Global Findex датабаазыг

хөгжүүлснээр дэлхий даяар насанд хүрэгчид хадгаламж, зээл, төлбөр, эрсдэлээ хэрхэн удирдаж байгаа талаарх цогц мэдээллийн сан бий болсон (Demirgьз–Kunt & Klapper, 2012), (Demirgьз–Kunt et al., 2020).

Санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн эрэлт талын мэдээлэл манай улсад ч нэлээд хомс байдаг. СЗХ санхүүгийн хүртээмжийн эрэлтийн талын судалгааг анх 2018 онд хийсэн (СЗХ, Эн Ар Си Си, 2018). Уг судалгаанаас банкны үйлчилгээний хүртээмж өндөр бөгөөд хүйсийн ялгаа байхгүй гэж дүгнэжээ. 2021 онд Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи банкны салбарын санхүүгийн хүртээмжийн судалгаа хийсэн бөгөөд банкны үйлчилгээний хүртээмж 94% гарсан нь бусад улсуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж

Энэхүү бүлэгт иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмж, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах сонирхол болон хамрагдахгүй байгаа шалтгаанд дүн шинжилгээ хийснийг танилцуулж байна. Санхүүгийн хүртээмж, түүнийг хэмжих талаар олон улс болон үндэсний хэмжээнд хийгдсэн судалгаа, тайлан, зөвлөмж зэрэг баримт бичгүүдэд тулгуурлан олон улсад өргөн ашиглагддаг санхүүгийн хүртээмжийн эрэлттэй холбоотой гол үзүүлэлтүүдийг сонгосон. Санхүүгийн хүртээмжийн эрэлтийн эдгээр үзүүлэлтийн тодорхойлолт болон судалгаанаас үнэлсэн үр дүнг хүснэгтэд нэгтгэн харууллаа. Санхүүгийн хүртээмжийг тухайн санхүүгийн үйлчилгээг хэрэглэдэг иргэдийн нийт иргэдэд эзлэх хувиар хэмжсэн болно.

Судалгаанд хамрагдсан ихэнх иргэд банкны үйлчилгээг авдаг. Харин банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын үйлчилгээний эрэлт харьцангуй бага байна. Тухайлбал, хэрэглэгчдийн гуравны хоёр нь ББСБ, дөрөвний нэг нь даатгал, тавны нэг нь ломбардын үйлчилгээг авдаг бөгөөд брокер, дилер, ХОС, ХЗХ-оор үйлчлүүлдэг хэрэглэгчид харгалзан 4.4%, 3.6% байна. Иргэдийн санхүүгийн үйлчилгээнд итгэх итгэл болон үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд санхүүгийн байгууллагуудаар ихээхэн ялгаатай байна.

Судалгаанд хамрагдсан иргэд бараг бүхэлдээ (99%) банкны үйлчилгээ авдаг хэдий ч банкнаас бусад байгууллагууд болох ББСБ, даатгал, брокер, дилер, ХОС, ХЗХ болон ломбардын үйлчилгээний хэрэглээ эрс бага байгааг

Хүснэгтээс харж болно. Эдгээр байгууллагууд дотроос ББСБ-ын үйлчилгээ авдаг хувь хамгийн өндөр бол ХЗХ-ны үйлчилгээ хамгийн бага байна.

Хүснэгт. Санхүүгийн үйлчилгээ авдаг байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	ББСБ	Даатгал	Брокер, дилер, ХОС	ХЗХ	Ломбард
Санхүүгийн үйлчилгээг авдаг хувь	35.8%	24.4%	4.4%	3.6%	20.0%
Бүлгүүдээр статистикийн хувьд ач холбогдолтой эсэх					
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм (-)
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Үгүй	Тийм (+)	Үгүй	Тийм (+)
35-аас доош настай	Тийм (+)	Тийм (-)	Үгүй	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Тийм (+)	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй
Өндөр орлоготой	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Ажилтай	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Тийм (+)	Тийм (+)	Үгүй	Үгүй	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн ttest-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.


Брокер, дилер, ХОС болон ХЗХ-ны үйлчилгээний хувьд маш цөөн иргэд хамрагддаг. Иймд эдгээр үйлчилгээг хэрэглэхгүй байгаа шалтгаан болон хэрэглэх сонирхол нь бүлгээр ялгаатай эсэхийг шинжиллээ.

Судалгаанаас ББСБ-ын үйлчилгээг иргэд зээлийн зорилгоор илүүтэй авдаг болох нь ажиглагдлаа. ББСБ-аар үйлчлүүлэгчдийн талаас илүү хувь нь хэрэгтэй үед зээл авч чаддаг учраас уг байгууллагаар үйлчлүүлдэг ажээ. Иймд ББСБ болон ломбардын үйлчилгээний хүртээмжийг банкны үйлчилгээтэй харьцуулах байдлаар шинжилгээг хийлээ. Харин даатгал, брокер, дилер, ХОС болон ХЗХ-ны үйлчилгээний хувьд оролцох сонирхол болон хамрагдахгүй байгаа шалтгаан зэргийг илүү дэлгэрүүлэн шинжилсэн.

ББСБ болон ломбардын үйлчилгээ

Иргэдийн ББСБ-ын үйлчилгээнд хамрагдалт нь нас, гэрлэлт, боловсрол, ажил эрхлэлт болон орлогын түвшин зэргээс хамаарч ялгаатай байдаг бол ломбардын хувьд байршил болон хүйсээс хамаарч ялгаатай байдаг. Зурагт ББСБ болон ломбардын үйлчилгээний хэрэглээг нийгэм, эдийн засгийн тодорхой бүлгүүдээр илүү дэлгэрэнгүй харууллаа.

Зураг. ББСБ, ломбардын үйлчилгээний хүртээмж, нийгэм эдийн засгийн шинж чанараар



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Ломбардаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж хүйсээр ялгаагүй. Эмэгтэйчүүд хүү өндөртэй ломбардын үйлчилгээг эрэгтэйчүүдээс илүү авч буй нь анхаарал татаж байна. Эмэгтэйчүүдийн 24% нь ломбардаар үйлчлүүлж байгаа нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 9 пунктээр илүү байна. Мөн түүнчлэн байршлын хувьд Улаанбаатарт байдаг иргэдийн ломбардын хэрэглээ (28%) байгаа нь орон нутагт амьдардаг иргэдтэй (13%) харьцуулахад 14 пунктээр илүү байна.

Мөн ББСБ-ын үйлчилгээний хүртээмж эдгээр шинж чанаруудаар ач холбогдол бүхий ялгаатай байгаа юм. Ажилтай, өндөр орлоготой, боловсролын түвшин өндөр бөгөөд байнгын цалингийн орлоготой иргэд ББСБ-ын үйлчилгээнд илүүтэй хамрагддаг.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж банк болон банкнаас бусад салбараар эрс ялгаатай байгаад юу нөлөөлж буйг ойлгохын тулд хэрэглэгчдээс тухайн байгууллагаар үйлчлүүлдэг шалтгааныг тандсан бөгөөд энэ нь байгууллагуудаар хэр ялгаатай байгааг шинжилж үзлээ. Судалгаанд хамрагдсан иргэдийн 30.8% нь банкаар үйлчлүүлдэг хоёр, 26.7% нь гурав, 14.8% нь дөрвөн шалтгааныг сонгосон байна. Хамгийн түгээмэл нь мөнгө шилжүүлж, шилжүүлэн авах (83.2%), төлбөр хийх (70%), мөнгөө хадгалахад тусалдаг (44.4%) болон хэрэгтэй үедээ зээл авч чаддаг (32.6%) гэсэн шалтгаанууд ажээ.

Зээлийн үйлчилгээ

Монгол Улс банкны үйлчилгээнд хамрагдалтын үзүүлэлтээр санхүүгийн хүртээмж өндөр хэдий ч банкны зээлийн бүтээгдэхүүний хэрэглээгээр хөгжлийн хувьд ижил түвшний орнуудтай харьцуулахад доогуур байдаг. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөрийн үндэслэлд зээлийн бүтээгдэхүүн өндөр зардалтай байгааг дурдсан байна.

Энэхүү судалгаанд хамрагдсан иргэд бараг бүгд банкны үйлчилгээ авдаг хэдий ч ердөө 30 шахам хувь нь банкнаас зээл авсан байна (Хүснэгт). Нөгөөтгээгүүр ердөө гуравны нэг нь ББСБ-ын үйлчилгээ авдаг боловч тавны нэг нь ББСБ-аас зээл авсан байна. Иргэд банкны зээлтэй эсэх нь насны бүлэг болон орлогын түвшнээс бусад шинж чанараар ямар нэг ялгаагүй байхад ББСБ-ын зээлийн хувьд олон шинж чанараар бүлгийн ялгаатай байна.

Хүснэгт. Зээл авсан байдал нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	Банкны зээл	ББСБ-ын зээл	Ломбардын зээл
Нийт зээл авсан хувь	29.40%	20.40%	9.20%
Бүлгүүдээр статистикийн хувьд ач холбогдолтой эсэх			
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Тийм (-)
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Үгүй	Тийм (+)
35-аас доош настай	Тийм (-)	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Үгүй	Тийм (+)	Үгүй
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Үгүй	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Үгүй	Тийм (+)	Үгүй
Өндөр орлоготой	Тийм (+)	Тийм (+)	Үгүй
Ажилтай	Үгүй	Тийм (+)	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Үгүй	Тийм (+)	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн ttest-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.

ББСБ нь банкны үйлчилгээний гадна үлддэг эмзэг бүлгийн буюу орлого багатай иргэдэд хүрч үйлчлэх боломжтой бичил санхүүгийн байгууллага хэдий ч энэхүү судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд орлого өндөр, ажилтай бөгөөд боловсрол өндөртэй нь ББСБ-аар илүүтэй үйлчлүүлж байна.


Судалгаанд оролцогчдын 48.8% нь өнгөрсөн 6 сарын хугацаанд зээл авсан гэж хариулсан бөгөөд давхардсан тоогоор зээл авсан иргэдийн 60.2% нь банкаар, 41.8% нь ББСБ-аар, 18.9% нь ломбардаар, 0.4% нь ХЗХ-оор үйлчлүүлсэн байна. Нийт зээл авсан хэрэглэгчдийн 82.4% нь нэг, 13.9% нь хоёр, 3.7% нь гурван санхүүгийн байгууллагаас зээл авчээ.

Өнгөрсөн зургаан сарын хугацаанд зээл авсан эсэхийг асуухад нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 48.8% нь зээл аваагүй гэжээ. Нийт зээл аваагүй хэрэглэгчдийн 69.7% нь зээл авах шаардлагагүй, 20.6% нь төлж байгаа зээлтэй, 12.2% нь мөнгө зээлэхийг хүсдэггүй эсвэл мөнгө зээлэхэд итгэдэггүй, 5.9% нь өрөө төлж чадахгүй байх гэж санаа зовдог гэсэн бол 5% нь зээл авах нь бэрхшээлтэй учраас гэж хариулжээ.

Даатгалын үйлчилгээ

Энэ судалгаагаар зөвхөн сайн дурын даатгалын үйлчилгээг хамарсан бөгөөд иргэдийн хүсэл сонирхлоос гадна хууль эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай албан журмын даатгалыг хамруулаагүй. Судалгаанд хамрагдсан иргэдийн 24.4% нь сайн дурын даатгалын үйлчилгээнд хамрагдсан бөгөөд хамрагдсан байдал нь хүйс болон байршлаас бусад шинж чанараараа статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатай байна. Өөрөөр хэлбэл иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт насны бүлэг, гэрлэлтийн статус, сууцны төрөл, боловсролын түвшин, орлогын түвшин болон ажил эрхлэлт зэргээс хамаарч ялгаатай байна (Зураг).

Зураг. ББСБ, ломбардын үйлчилгээний хүртээмж, нийгэм эдийн засгийн шинж чанараар



Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Сайн дурын даатгалд байнгын орлоготой, ажилтай, өндөр орлоготой, бакалавр ба түүнээс дээш боловсролтой, гэрлэсэн, орон сууцанд амьдардаг бөгөөд 35 ба түүнээс дээш насны иргэд эсрэг бүлгийнхнээсээ илүүтэй хамрагддаг. Сайн дурын даатгалд хамрагддаг иргэдийн 71.1% нь эрсдэлээс сэргийлэх зорилгоор харин 20.1% нь үйлчилгээ үзүүлсэн болон ажил олгогч гэх мэт байгууллагын шаардлагын дагуу сайн дурын даатгалд хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 79.3% нь энэ хоёр шалтгааны нэгийг харин 20.7% нь хоёуланг нь сонгожээ. Эндээс даатгалд хамрагддаг иргэдийн хувьд эрсдэлээс сэргийлэх буюу өөрийн сонголтоор түгээмэл хэрэглэдэг хэдий ч тодорхой хэсэг нь бусдын шаардлагаар сайн дурын даатгалд хамрагддаг гэж дүгнэж болохоор байна.

Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол, итгэх итгэл

ББСБ, ломбард, үнэт цаасны компаниуд (ҮЦК) болон ХЗХ-ны үйлчилгээг сонирхож байсан эсэх, үйлчилгээг авдаггүй шалтгаан болон итгэх итгэл гэсэн үзүүлэлтүүдийг хэмжиж, эдгээр үзүүлэлтүүдэд нийгэм, эдийн засгийн шинж чанараас хамааралтай ялгаа байгаа эсэхэд шинжилгээ хийлээ.

Санхүүгийн үйлчилгээнд хамрагдалт банкнаас бусад байгууллагууд, тэр дундаа ҮЦК-иуд болон ХЗХ-ны хувьд эрс бага төдийгүй үйлчлүүлдэггүй хүмүүс дунд сонирхож байсан гэх хариулт маш бага байгаа нь анхаарал татаж байна. Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 95.6% нь брокер, дилер, ХОС-ын үйлчилгээнд хамрагддаггүй бөгөөд эдгээр иргэдийн тав хүрэхгүй хувь нь энэ үйлчилгээг өмнө нь сонирхож байсан гэсэн бол ХЗХ-ны үйлчилгээ авдаггүй 476 иргэний 1.5% нь уг үйлчилгээг сонирхож байсан байна. Даатгалд хамрагдаагүй 375 иргэний 11.5% нь сайн дурын даатгал сонирхож байсан гэжээ (Хүснэгт).

Хүснэгт. Санхүүгийн үйлчилгээг авах сонирхол нийгэм, эдийн засгийн шинж чанараар ялгаатай эсэх

	Сонирхож байсан эсэх		
	Даатгал	Брокер, дилер, ХОС	ХЗХ
Үйлчилгээ авдаггүй иргэдээс үйлчилгээг өмнө нь сонирхож байсан %	11.50%	4.90%	1.50%
Эрэгтэй	Үгүй	Үгүй	Үгүй
Улаанбаатарт амьдардаг	Үгүй	Тийм (+)	Үгүй
35-аас доош настай	Тийм (-)	Үгүй	Үгүй
Гэрлэсэн	Тийм (+)	Үгүй	Тийм (+)
Орон сууцанд амьдардаг	Үгүй	Тийм (+)	Үгүй
Бакалавр ба дээш боловсролтой	Үгүй	Тийм (+)	Үгүй
Өндөр орлоготой	Үгүй	Үгүй	Үгүй
Ажилтай	Тийм (+)	Үгүй	Үгүй
Байнгын ажлын орлоготой	Үгүй	Тийм (+)	Үгүй

Эх сурвалж: Санхүүгийн хүртээмжийн тоон өгөгдлөөс тооцоолов.

Тайлбар: Тухайн бүлэг бүрээр хийсэн ttest-ын p-утга 5%-иас бага бол статистикийн хувьд ач холбогдолтой буюу тухайн бүлгээр ялгаатай буюу тийм, p-утга 5%-иас их бол ач холбогдолгүй буюу тухайн бүлгээр ялгаагүй буюу үгүй гэж тэмдэглэв. Ач холбогдолтой үзүүлэлтүүдийн хувьд эерэг сөрөг нөлөөг хаалтад нэмэх хасах тэмдгээр харууллаа.

ДҮГНЭЛТ

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж банк болон банкнаас бусад салбарын хооронд эрс тэс ялгаатай. Нийт иргэдийн 99% нь банкны үйлчилгээ авдаг бол ББСБ, даатгал, ҮЦК-иуд, ХЗХ болон ломбард зэрэг бусад төрлийн санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг хувь эрс бага байна. Банкнаас бусад салбаруудын хувьд ББСБ-ын үйлчилгээг авдаг хувь хамгийн өндөр бол ХЗХ-ны үйлчилгээ хамгийн бага байна.

Ломбардын үйлчилгээнээс бусад үйлчилгээний хүртээмж хүйсээр ялгаагүй. Хүү өндөртэй зээлийн үйлчилгээнд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүүтэй үйлчлүүлж байгаа нь анхаарал татаж байна. Энэхүү ялгаанд юу нөлөөлж байгааг цааш гүнзгийрүүлэн судлах нь сонирхолтой байж болох юм. Олон улсад ч эмэгтэйчүүд ломбардын үйлчилгээг илүү авдаг байдал ажиглагддаг. Иргэд өдөр тутмын хүнс, хоол гэх мэт зүйлсийн санхүүжилтэд зориулж ломбардын үйлчилгээ авдаг нь мөн Их Британийн ломбардын хэрэглэгчдийн түүвэр судалгаанаас гарчээ.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж нь иргэдийн амьжиргааны түвшин, боловсролын түвшин, нас болон ажил эрхлэлтийн статусаас хамаарсан ялгаа ихтэй байна. Харин хүйс болон байршлаас хамаарсан ялгаа багатай. Орлого багатай, ажилгүй бөгөөд бага боловсролтой иргэдийн банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байна. ББСБ-ын үйлчилгээ нь банкны үйлчилгээний гадна үлдэж буй иргэдэд хүрч үйлчлэх боломжтой бичил санхүүгийн салбар гэсэн жишиг олон улсад байдаг. Харин энэхүү судалгаагаар ББСБ-аас илүүтэй ломбардын үйлчилгээнд орлого багатай иргэд хамрагддаг нь ажиглагдлаа. ББСБ-ын үйлчилгээ нь орлого багатай иргэдийг хамруулахаас илүүтэй нийт иргэдийн хурдан, шуурхай зээл авах хэрэгцээг хангахад чиглэдэг ажээ. Банкаар үйлчлүүлэгчдийн дийлэнх нь мөнгө шилжүүлэх, шилжүүлж авах, төлбөр тооцоо хийхийн тулд банкиг ашигладаг гэжээ.

Банкнаас бусад санхүүгийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа хэрэглэгчдийн дийлэнх нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулж байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа, даатгал болон хөрөнгийн зах зээл, ХЗХ-ны үйлчилгээг хэрэгцээ шаардлагагүй учраас авдаггүй гэж үйлчлүүлдэггүй хүмүүсийн талаас илүү хувь нь хариулжээ. Нөгөө талаас энэ төрлийн санхүүгийн үйлчилгээний талаар мэдэхгүй гэсэн хариулт их байна. Мөн түүнчлэн, даатгал, ҮЦК-иуд болон ХЗХ-ны үйлчилгээний талаар тодорхой ойлгомжтой мэдээлэл авсан гэж маш бага хувь нь хариулжээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ◆ Sara Davies & Andrea Finney, “Pawnbroking customers in 2020: a survey of pawnbroking customers” University of Bristol Personal Finance Study Centre: Bristol, UK, 2020
- ◆ Demirgьз–Kunt, Asli and Klapper, Leora F., “Measuring Financial Inclusion: The Global Findex Database”. World Bank Policy Research Working Paper No. 6025, SSRN, 2012, ssrn.com/abstract=2043012, Accessed 15 December 2024
- ◆ Asli Demirgьз–Kunt, Leora Klapper, Dorothe Singer, Saniya Ansar, & Jake Hess, “The Global Findex Database 2017: Measuring financial inclusion and opportunities to expand access to and use of financial services.”, The World Bank Economic Review, 2020
- ◆ Antonia Grohmann, Theres Klyhs, Lukas Menkhoff, “Does financial literacy improve financial inclusion? Cross country evidence.”, World Development, 2018, p.84–96
- ◆ Antonia Grohmann, Lukas Menkhoff. “The relationship between financial literacy and financial inclusion.”, The Routledge Handbook of Financial Literacy, Routledge, 2021, p.517–530. Available at: www.taylorfrancis.com/chapters/edit/10.4324/9781003025221-39/relationship-financial-literacy-financial-inclusion-antonia-grohmann-lukas-menkhoff, Accessed 15 December 2024
- ◆ AFI, “Indicators of the quality dimension of financial inclusion”, FID Guideline note No.22, Alliance for Financial Inclusion, 2016 (August)
- ◆ Leora Klapper, Annamaria Lusardi, & Peter van Oudheusden, “Financial Literacy Around the World: Insights from the standard & poor’s ratings services global financial literacy survey” World Bank. Washington DC: World Bank, 2015, p.218–237.
- ◆ OECD, “OECD/INFE Toolkit for Measuring Financial Literacy and Financial Inclusion 2022”, OECD Publishing, Paris, 2022, doi.org/10.1787/cbc4114f-en, Accessed 15 December 2024
- ◆ OECD, “OECD/INFE 2023 International Survey of Adult Financial Literacy”, OECD Business and Finance Policy Papers, No. 39, OECD Publishing, Paris, 2023, doi.org/10.1787/56003a32-en, Accessed 15 December 2024
- ◆ Olzii, Peterson K., “Financial inclusion research around the world: A review”, Forum for Social Economics, 2021, p.457–479, doi.org/10.1080/07360932.2020.1715238, Accessed 15 December 2024
- ◆ Olzii, Peterson K., Adekemi Ademiju & Semia Rachid, “Impact of financial inclusion on economic growth: Review of existing literature and directions for future research”, International Journal of Social Economics, 2023, p.1105–1122, doi.org/10.1108/IJSE-05-2022-0339, Accessed 15 December 2024
- ◆ Venesa PesquCela, Lihui Tian, Deming Luo, Damian Tobin, Gerhard Kling, “Defining and measuring financial inclusion: A systematic review and confirmatory factor analysis.”, Journal of International Development, 2021, Vol.33, Issue.2, p.316–341, doi.org/10.1002/jid.3524, Accessed 15 December 2024
- ◆ World Bank Group, “Global Financial Inclusion and Consumer Protection Survey, 2017 report”, World Bank, Washington, DC, 2017, hdl.handle.net/10986/28998, Accessed 15 December 2022

Гэнэтийн ослын, эмчилгээний даатгал гэж юу вэ?



Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний **амь нас, эрүүл мэндэд** хохирол учрахад даатгалын үнэлгээнээс хамааран нөхөн төлбөр олгох зорилго бүхий **сайн дурын даатгал** юм. Үүнд хөдөлмөрийн чадвар сэргэх хүртэлх хугацааны эмчилгээний зардал зэрэг.

Даатгалд хамрагдах эрсдэлийн төрлүүд



Ахуйн эрсдэл

Элдэв зүйлд зохиулах, дарагдах, хавчигдах, явганаас унаж бэртэх, халтирах, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед гал, шаталт, дэлбэрэлтийн нөлөөгөөр учирсан гэмтэл, бэртэл, түлэгдэлт;

Аянга буух, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөр, усны үер, газар хөдлөлт болон ой хээрийн түймэр гэх мэт;



Байгалийн эрсдэл



Мал амьтдын нөлөөгөөр үүсэх эрсдэл

Морь малаас унах, чирэгдэх, хазуулах, араатан амьтан, нохойд уруулах, хортой шавж болон хачиг, нисдэг биетэд хазуулах, могойд хатгуулах гэх мэт;



Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэл



Хүүхдийн гэнэтийн ослын даатгал

Манай улсын нийт хүн амын 38.8 хувийг 0–19 насны хүүхдүүд эзэлдэг. Сүүлийн гурван жилийн дунджаар 40 гаруй мянган хүүхэд сургууль, цэцэрлэг болон ахуйн орчинд аливаа гэнэтийн осолд өртсөн байна.



Хүүхдээ аюулгүй байлгаж, ирээдүйг нь хамгаалъя



Гэнэтийн ослын даатгалын үйлчлэх хүрээ :

- Сургууль, олон нийтийн гудамж талбай болон ахуйн бүх орчинд 24 цаг үйлчилнэ.
- Гэнэтийн ослын даатгалд хүүхэд бүр хамрагдах боломжтой.
- Гэмтэл бэртлээс үүдэлтэй эм тариа, эмчилгээний зардлыг даатгагчаас олгогддог.

Хүүхдийн даатгалын бүтээгдэхүүнүүд:



Хүүхдийн гэнэтийн ослын даатгал



Боловсролын хуримтлалын даатгал



Хурдан морь унаач хүүхдийн даатгал



Хуримтлалын даатгал

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

THE HONGKONG AND SHANGHAI BANKING CORPORATION (HSBC) ЕВРОП, АМЕРИК ДАХЬ М&А БОЛОН ЕСМ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЗОГСООХООР ШИЙДВЭРЛЭВ.



HSBC банк Их Британи, Европ, Америк дахь М&А болон ЕСМ салбараасаа гарахаар болжээ. Энэ нь тус банкны шинэ гүйцэтгэх захирал Жорж Эльхедеригийн зардлыг танах стратегийн хүрээнд хийгдэж буй томоохон өөрчлөлт юм.

Банкны удирдлагуудад илгээсэн дотоод мэдэгдэлд дурдсанаар HSBC нь Ази, Ойрх Дорнод дахь гол зах зээлээс бусад бүс нутаг дахь үндсэн бус хөрөнгө оруулалтын банкны зарим үйл ажиллагаанаас гарахаар төлөвлөж байна.

Энэхүү алхам нь HSBC-ийн зардлыг бууруулах, илүү стратегийн ач холбогдол бүхий зах зээлүүдэд төвлөрөх бодлогын нэг хэсэг гэж үзэж байна.

Эх сурвалж: www.reuters.com

ТРАМПЫН "ДИЖИТАЛ ДОЛЛАР"-ЫГ ХОРИГЛОХ ШИЙДВЭР ХЯТАД, ЕВРОПЫН СВДС ЧӨЛӨӨТЭЙ ХӨГЖИХ БОЛОМЖ ОЛГОВ.



Ерөнхийлөгч Дональд Трампын "Дижитал доллар"-ыг хориглох шийдвэр нь Хятад болон Европын төв банкны дижитал валют (CBDC)-ын хөгжлийг саадгүй болгож, тэдгээрийг дэлхийн шинэ санхүүгийн стандарт тогтоогч болох боломжийг бүрдүүлээ гэж ажиглагчид үзэж байна.

АНУ дэлхийн тэргүүлэгч нөөц валют болох ам.долларын дижитал хувилбарыг хөгжүүлэхээс удаан хугацаанд болгоомжтой хандаж ирсэн. Гэвч одоо ийм төрлийн хөрөнгийг ерөнхийлөгчийн зарлигаар хориглосон цорын ганц улс болсон нь анхаарал татахгүй байхын аргагүй үйл явдал юм.

Эх сурвалж: www.reuters.com



ХЯТАДЫН DEEPSEEK КОМПАНИЙН НӨЛӨӨГӨӨР ХИЙМЭЛ ОЮУН УХААНТАЙ ХОЛБООТОЙ ХУВЬЦААНУУД ХЭЛБЭЛЗЭЛТЭЙ ХЭВЭЭР БАЙНА.



АНУ-ын технологийн хувьцаанууд огцом уналтаас хойш хэлбэлзэлтэй хэвээр байна. Энэ уналт нь Хятадын ChatGPT-тэй төстэй шинэ AI платформ "DeepSeek"-ийн нээлттэй холбоотой бөгөөд энэ нь хиймэл оюун ухааны өрсөлдөөнд АНУ-ын давамгайлалд сорилт болж байна.

Nvidia компанийн хувьцаа дахин 2%-иар буурсны дараа бага зэрэг өсөж, бичиж байх үеийн байдлаар 2%-иар нэмэгдсэн байна. Энэ нь 17%-ийн уналт, 600 тэрбум ам.долларын зах зээлийн үнэлгээний алдагдлын дараах сэргэлт юм. Энэхүү уналт нь түүхэндээ хамгийн том нэг өдрийн зах зээлийн үнэлгээний алдагдал болж бүртгэгдсэн юм.

Дональд Трамп Хятадын DeepSeek компанийн чатботын нээлтийг АНУ-ын технологийн компаниудын хувьд хиймэл оюун ухааны дэлхийн өрсөлдөөнд давамгайлахын тулд сэрэмжлүүлэг болсон ("wake-up call") үйл явдал гэж мэдэгдлээ.

Шинжээчид DeepSeek платформыг болгоомжтой ашиглахыг зөвлөж байна. Тэдний гол санаа зовниж буй асуудал нь Хятадын төрөөс хэрэглэгчдийн өгөгдлийг ашиглах магадлалтай байдал болон худал мэдээлэл тараах эрсдэл юм.

Эх сурвалж: www.theguardian.com

АНУ-ЫН ТЕХНОЛОГИЙН ХУВЬЦААНЫ УНАЛТ, ТАРИФЫН БОДЛОГЫН ШОК НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫГ ШИНЭ АЮУЛГҮЙ ЗАХ ЗЭЭЛ ХАЙХАД ХҮРГЭВ.



Ерөнхийлөгч Дональд Трампын тарифын бодлого, АНУ-ын технологийн хувьцааны уналт, ам.долларын хэлбэлзэл нь зах зээлд тогтворгүй байдал үүсгэж, хөрөнгө оруулагчид Японы иен, Европын зээл зэрэг тогтвортой хөрөнгөнд хошуурч эхэлжээ.

Трампын эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлогыг сайшааж байсан зах зээлүүд огцом хэлбэлзэлд орж, газрын тосны үнэ, Канад болон Мексикийн валютууд хэлбэлзэж, инфляцын таамаглал тодорхойгүй болж, АНУ-ын бондын зах зээлд эрсдэл нэмэгдэж байна.

Үүний зэрэгцээ, хөрөнгө оруулагчид шинэ Цагаан ордны засаг захиргааг санхүүгийн зах зээлд эрсдэл үүсгэгч хүчин зүйл гэж үзэж эхэлжээ.

Эх сурвалж: www.reuters.com

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр

S&P 500 / ^GSPC/

6,101.24 -17.47 (-0.29%)



Nikkei 225 / ^N225/

39,876.85 -53.34 (-0.13%)



FTSE 100 / ^FTSE/

8,502.35 -62.85 (-0.73%)



NASDAQ Composite (^IXIC)

19,954.30 -99.40 (-0.50%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

ШУДАРГА ЕС-ХӨГЖИЛ ДЭВШИЛД

110

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ УТАС
/үнэ төлбөргүй/

